



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА,
ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ЗАХИРАМЖ**

2015 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/89-А/342

Улаанбаатар хот

**Хороодод "Найрсаг-Баянгол" өдөрлөг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3, 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 18 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Найрсаг-Баянгол" хөтөлбөрийн хүрээнд хороодын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах зорилгоор дүүргийн 23 хороонд "Найрсаг-Баянгол" өдөрлөгийг 2015 оны 05 дугаар сарын 16-17, 23-24-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр, дэмжлэг үзүүлж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, өдөрлөгийн хуваарийг гуравдугаар, анонсны загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Өдөрлөгийн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, хорооны Засаг дарга, иргэдийн Нийтийн Хурлын дарга нар болон Ажлын хэсэгт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ДЭЛГЭРБАТ

ЗАСАГ ДАРГА



Д.ОРОСОО